



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Арга хэмжээ авч ажиллах тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/71 тоот тушаал, “Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийх ажлын удирдамж”-ийн хүрээнд 2017-2018 онд зохион байгуулагдсан тооллогын дүнгээр улсын хэмжээнд уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн 24, 347.5 га талбайг бүртгэж, нийт 1491 газар буюу 9381.4 га талбайг нөхөн сэргээх шаардлагатай байгааг тогтоосон.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх, Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-д Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг заасан байдаг.


Гэвч орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайд тавих хяналт, уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлэх ажил хангалтгүй байна.

Иймд дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлтийн ажлыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт

1. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт эвдэрсэн газрын тооллогод хамрагдсан эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх тодорхой хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаж, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих
3. Нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох журмын дагуу чанартай гүйцэтгүүлж, “Нөхөн сэргээлт хүлээн авах акт”-ын дагуу хүлээж авах
4. Үйл ажиллагаа явуулсан газартаа нөхөн сэргээлт хийлгүй орхисон, үүрэг хариуцлагаа биелүүлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг холбогдох хуулийн дагуу Цагдаагийн байгууллагад хүргүүлэх
5. Цагдаагийн Ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай байнгын уялдаа холбоотой хамтран ажиллах.

Албан даалгаврын хэрэгжилт, гүйцэтгэлийн явцыг 2020 оны 05 дугаар сарын 01-ний дотор гарган ирүүлэхийг даалгаж байна.

САЙД  Н.ЦЭРЭНБАТ

010004